

Улсын бүртгэлийн
дугаар.....

Нууцын зэрэглэл:

Аравтын бүрэн
ангилалын код

Төсөл хэрэгжүүлэх гэрээний
дугаар: ШудД_2017/05

**ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИ
ТҮҮХ, УГСААТНЫ ЗҮЙН ХҮРЭЭЛЭН**

**АРВАНДОЛДУГААР ЗУУНЫ ҮЕИЙН ХОТУУДЫН СУДАЛГАА,
СОЁЛЫН ӨВИЙН ХАМГААЛАЛТ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН
ЦОГЦОЛБОР БОЛОХ НЬ**

**Шинжлэх ухаан технологийн захиалгат төслийн тайлан
2017-2019**

Төслийн удирдагч:

С.Чулуун

Санхүүжүүлэгч байгууллага:

Шинжлэх ухаан
технологийн сан

Захиалагч байгууллага:

БСШУСЯ

Тайлан өмчлөгч:

Түүх, угсаатны зүйн
хүрээлэн.
ШУА-ийн I байр, Баянзүрх
дүүрэг, Жуков-77, 13343
Улаанбаатар
Утас: 11-458305
И-мэйл: history@mas.ac.mn

**УЛААНБААТАР
2020**

АГУУЛГА

1. Удиртгал	2
2. Төслийн гүйцэтгэл	
2.1. Төслийн зорилтыг хангах тухайд.....	4
2.2. Төслийн зорилгыг хэрэгжүүлсэн тухай.....	4
2.3. Төслийн ажлыг гүйцэтгэхэд ажлын ерөнхий чиглэл, туршлагыг хэрхэн ашигласан тухай.....	14
2.4. Төслийн гэрээнд тусгагдсан эцсийн үр дүнг ерөнхийлөн авч үзвэл.....	16
2.5. Төслийг хэрэгжүүлсний үр дүнгийн шинэлэг буюу дэвшилтэт талын тухайд.....	18
2.6. Төслийг хэрэгжүүлснээр Монгол улсын эдийн засаг, нийгмийн болон шинжлэх ухаанд гарсан ач холбогдолын тухайд.....	19
2.7. Үр дүнг шилжүүлэх, борлуулах, ашиглах боломж, төслийн өртгийг нөхөх урьдчилсан тооцоо, хугацаа (бусдад худалдах, лицензийн гэрээгээр ашиглуулах, төсөл, сэдэвт ажлыг санаачлагч өөртөө үлдээх гэх мэт)	21
3. XVII зууны монголын хот, сүм хийдүүдэд 2017-2019 онд явуулсан ажиллагаа	22
3.1. Малтлага судалгаа.....	30
3.2. Сурталчилгаа, танин мэдэхүйн үйл ажиллагаа.....	32
3.3. Эрдэм шинжилгээний ном өгүүлэл, илтгэл.....	35
3.4. Бусад төлөвлөгөөний дагуу хийгдсэн ажил.....	39
4. Дүгнэлт.....	41
Хавсралт.....	

1. УДИРТГАЛ

Өнөөдөр хүртэл Монгол улсын газар нутаг дээр 10 гаруй энэ үеийн холбогдолтой түүхийн дурсгалт хотууд, хуучин сүм хийд үлдэж хоцорсон бөгөөд судлагааны эргэлтэд огт ороогүй, сүйтгэгдэж, соёлын өвийн хувьд маш дор байдалд ороод байна. Тиймээс энэ үеийн хотуудыг цогцоор нь археологи, угсаатны судлал, түүхийн талаас нь судлан шинжлэх, тэрхүү судалгааг үндэслэн хадгалалт хамгаалалтын асуудлыг шийдвэрлэх, хөтөлбөр боловсруулах, улмаар дотоодын болон гадаадын аялал жуулчлалын сүлжээнд холбон хөгжүүлэхэд гол зорилго оршиж байв.

Түлхүүр үг: Арвандолдугаар зуун, хот, суурин, аялал жуулчлал, хамгаалалт, Сарьдагийн хийд, Өвгөн хийд, Хар бухын балгас, Сүмийн толгой, Сүм хөх бүрд, Хэсэг байшин, Цогтын Цагаан байшин.

Төслийн удирдагч: Сампилдондовын Чулуун (РД: 77071470, ШУА-ийн Түүх, Угсаатны зүйн хүрээлэнгийн захирал, Түүхч, Түүхийн шинжлэх ухааны доктор (Sc.D), академич

Төслийн оролцогчид:

1. Б.Цогтбаатар (ШУА-ийн Археологийн хүрээлэнгийн салбарын эрхлэгч, доктор)
2. Л.Эрдэнэболд (ШУТИС-ийн БХУС-ийн багш, археологи, доктор, дэд профессор)
3. Ч.Энхтуул (ШУА-ийн Түүх, Угсаатны зүйн хүрээлэнгийн Монголын дундад зуун ба Эзэнт гүрний түүхийн судалгааны салбарын судлаач)
4. Э.Уртнасан (ШУА-ийн Түүх, Угсаатны зүйн хүрээлэнгийн Евразийн нүүдэлчид ба Монголын эртний түүх, археологийн судалгааны салбарын судлаач)
5. Н.Хатанбаатар (ШУА-ийн Түүх, Угсаатны зүйн хүрээлэнгийн Түүхийн эх сурвалж, баримт мэдээлэлийн төвийн судлаач)
6. Б.Батцоож (ШУА-ийн Түүх, Угсаатны зүйн хүрээлэнгийн Хэрэглээний угсаатны судлалын судалгааны салбарын судлаач)

7. Г.Бямбарагчаа (ШУА-ийн Түүх, Угсаатны зүйн хүрээлэнгийн Угсаатан, нийгмийн хүн судлалын судалгааны салбарын судлаач)
8. Д.Гэрэлтөв. Монголын аялал жуулчлалын Үндэсний Зөвлөлийн дарга
9. Бусад гэрээт ажилтан-14 хүн

Жич: төслийн үйл ажиллагаа явагдаж эхэлсэн үед зарим онцгой нарийн мэргэжлийн асуудал гарвал тухайн үед нь гэрээгээр ажиллуулсан болно.

2. ТӨСЛИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1. Төслийн зорилтыг хангах тухайд

Монголчуудын соёлын өвийг тодорхой он цагийн хүрээнд хамруулан судлах, дурсгалуудыг хадгалах хамгаалах, үндэсний хэмжээнд болон дэлхийд сурталчлах, таниулах нь өнөөгийн үед нэн чухал байна. Түүний нэг нь XVII зууны үеийн буюу Монголын Эзэнт гүрний дараах үеийн Монголын түүхийг тодорхойлох, өнөөг хүртэл огт судлагдаагүй шахам байгаа бүхэл бүтэн үеийн түүхийн хамааралтай судалгааг цогцоор нь явуулж, тэдгээрийг нэгдсэн журмаар хамгаалах, аялал жуулчлалын бүтээгдэхүүн болгон сурталчлах ажлын гол үндсэн суурь судалгааг явуулахад манай төслийн агуулга оршиж байв.

XVII зууны Монгол нутагт буй хот суурины судалгааг урьд өмнө ингэж цогцоор нь судалсан судалгаа нэн бага бөгөөд үнэн хэрэгтээ нэг ч хотыг тодорхойлох, нарийвчилсан малтлага судалгааг явуулаагүй байсан нь угс судалгааны өмнө тулгарч байсан гол зорилт болсон юм.

2.2. Төслийн зорилгыг хэрэгжүүлсэн тухай

Бид энэ өнгөрсөн 3 жилийн туршид зорилгоо биелүүлэхийн тулд Монгол нутагт байгаа XVII зууны хот, сүм хийдүүдийн нэгдсэн бүртгэл хийх, хотын зураглал, газарзүйн байршил, тодорхойлолт, холбогдолтой түүхийн эх сурвалж, баримтын мэдээлэл цуглуулах, археологийн тодорхой малтлага судалгааг системтэй явуулахыг зорьж ажилласан болно. Ялангуяа археологийн малтлага судалгааг явуулсны дараа хотын бүтэц зохион байгуулалт, олдвор зэрэгт үндэслэн аялал жуулчлалын нэгдсэн систем боловсруулах, мэдээлэлийн төвүүдийг байгуулах, олон түмэнд танилцуулах, зөв ойлголт өгөх, орон нутгийн болон улс бүсийн хамгаалалтад оруулах ажлыг зохион байгуулсан.

Монгол нутагт буй өгүүлэн буй үеийн хот суурин аль ч хэсэгт аялал жуулчлалын болох хамгаалалтын үйл ажиллагааг явуулахад шаардагдах судалгааны суурь, холбогдох эд хэрэглэгдэхүүн, он цаг, мэдээлэл, бүтэц зохион байгуулалтыг харуулсан зураглал бүгд хийгдсэн болно.

Соёлын өвийг судлах, хадгалах хамгаалах, сэргээн засварлах, танин мэдүүлэх гэсэн гурвалсан холбоонд тулгуурлан Шинжлэх ухаан, технологийн төслийн хүрээнд бүгдийг багтаан хийх боломж үүгээр бүрдэнэ гэж төлөвлөж ажилласан. Урьд өмнө хийгдээгүй өнөөг хүрсэн нэг шалтгаан нь үүнтэй холбоотой.

Харин 2017 онд БСШУСЯ-наас тусгай захиалгат ажлын хүрээнд уг төслийг дэмжснээр бидний судалгааны ажлын үндэслэл, шаардлагыг хангах бүрэн боломж бүрдсэн. Мэдээж санхүүжилт хангалттай бус, дан ганц малтлагад шаардлагатай төсвөөс гадна судалгааны бааз суурийг нэмэгдүүлэх, холбогдох сурвалж эх хэрэглэгдэхүүнийг цуглуулах зэрэг ажлууд нь дутагдалтай байсан ч бид тусгай захиалгат ажлын хүрээнд хийвэл зохих ажлуудыг үндсэнд нь бүрэн дуусгасан болно.

Гэвч цаашид хамгаалалт, сурталчилгаа, танин мэдэхүйн асуудал урьдын адил байнга хоцрогдсоор байгааг анхаарах хэрэгтэй байна. Ялангуяа эдгээр хотуудын тухай танилцуулга огт байхгүй, элдэв мал сүрэг, хууль бус анчид, тонуулчидаас хамгаалах хамгаалалтын орчин байхгүй байсаар байна.

Бидний судалгааны дүнгээс үзэхэд XVII зууны үеийн Монголын хотууд нь эзэнт гүрнээс хойш монгол улсыг оршин тогтнож байсныг илтгэхээс гадна сүм хийд, уран барилгын бүхэл бүтэн цогц нэгэн цэцэглэлтийн үе байсан гэж ойлгож болно. Тэр нь зөвхөн Монголчуудын дэмжлэгээр хийгдэж байсан буй өрнө дорнын олон ард түмний дэмжлэгээр 16 зуун ч тэр хожуу 18 зуун ч тэр ийм цогц хотын хөгжил буй болгоогүй байжээ. Нүүдэлчдийн ертөнцийг хот сууринтай хослуулан хөгжүүлэх, орчин үежилтийн эхэн үе энэ үед тавигдсныг дэлхийн олон эрдэмтэд онцлон үздэг.

XVII зууны Монгол нутаг дахь хотууд нь Чингис хааны эзэнт гүрнээс Манж Чин улсад дагаар орох үе хүртлэх түүхэн зурвас, олон түмэн бараг мэдэдгүй нэгэн чухал үеийг тодорхойлох 10 гаруй хот, сүм хийдийн туурь үлдэж хоцорсон нь маш том судалгаа шинжилгээ, аялал жуулчлалын боломж байгааг бидний судалгааны үр дүн нотлоно. Өнөөг хүртэл Монголын хувьд аялал жуулчлалын сүлжээнд эдгээрийг ашиглаж байгаа ч ямар ч судалгаа шинжилгээ, хадгалалт хамгаалалт байхгүй байна. Тухайлбал Цогт тайжийн Цагаан байшин, Хар балгас, Хөгнө Тарна уулын Өндөр гэгээний Өвгөн хийд, Төвхөн хийд, Хэнтийн нуруунд буй Сарьдагийн

хийд, Дундговийн Адаацаг суман дахь Сүм хөх бүрд, Тэс голын хөвөөнд орших Сүмийн толгой зэрэг хотуудын туурийг тухай тухайн чиглэлийн аялал жуулчлалын маршрутад хэрэглэж болохоор байна. Эдгээр хот, сүм хийдэд бид бүгдэд нь нарийвчилсан судалгааг эхний шатанд хийж гүйцэтгээд байна. Гэвч тодорхой мэдээлэлгүй, аялал жуулчлалын ямар ч мэдээлэл байхгүй, жуулчдад үзэж сонирхох зүйлгүй хэвээр л байна.

XVII зууны эдгээр хот, сүм хийд нь Монголын түүх төдийгүй бүс нутаг дэлхийн түүхэнд хэрхэн чухал, ач холбогдол өндөртэй болох төдийгүй бид дараахь байдлаар танилцуулая.

Хүснэгт 1. Малтлага судалгаа.

№	Хотын нэрс	Малтлага судалгаа явуулсан тойм	Тайлбар
1. Үндсэн судалгаа			
1	Цагаан байшин	Цогт тайжийн цагаан балгасанд анх 19 зууны эцэст Оросын эрдэмтэн В.В.Радловоос хойш Монголын эрдэмтэн Х.Пэрлээ нар гүймэг судалгааг нэг удаа явуулснаас хойш нарийвчлан малтан судалсан нь огт үгүй байсан юм. Тус төслийн хүрээнд 2017 оны 8 сард анх тус хотын дэвсгэр зургийг хийх, дээд талын жижиг сүмийн туурьд бага зэргийн малтлага судалгаа явуулав. Нилээд тооны дурсгалуудыг илрүүлэн олсон бөгөөд хэлбэр хийц, он цагийн хувьд ихээхэн өвөрмөц дурсгал болох нь мэдэгдсэн юм.	Цогт хунтайжийн өөрийн байгуулсан гэх уг сүм нь бухар хийцийн хэмээгдэх энэхүү цагаан байшин болно. Энэ тухай ойролцоо орших монгол, төвд бичээстэй хөшөө чулуунд тодорхой байгаа юм. Хамгийн гол нь Цогт тайжийг шашны ямар урсгалтай байсныг биш боловч өвөрмөц хуучны дурсгалуудыг шүтэж байсныг гэрчлэх эд өлгийн зүйлс олдсон.
2	Сарьдаг хийд	Өндөр гэгээн Занабазарын байгуулсан хэмээгдэх Рибогэжайлингандуншадублин хийд буюу бидний үзэж буйгаар Хан	Өндөр гэгээн Занабазарын 1654-1686 онд байгуулсан Рибогэжайлинганданшадуб

		<p>хэнтийн нуруунд буй Сарьдагийн хийдийн туурьд өмнө явуулсан малтлага судалгааг үргэлжлүүлэх боломжийг энэхүү төслөөс олгосонд баяртай байна. Бид 2017 оны 6 сарын 24-нөөс 7 сарын 28 хооронд томоохон хэмжээний малтлага судалгааг явуулсан. Урьд өмнө Үндэсний хэмжээний хээрийн шинжилгээний анги болгож 2013 оноос эхлэн 4 удаа малтлага судалгаа явуулсан байсан тул тус төслийн дэмжлэгээр хамгийн сүүлийн жил малтлага судалгаа явуулж, орчны бүсэд хайгуул судалгааг явуулсан. Мөн тус төслийн хүрээнд XVII зууны монголын хотын судалгааг төлөөлүүлэн “САРЬДАГИЙН ХИЙД: Өндөр гэгээн Занабазарын уран бүтээлийн хүрээ” түүх-археологийн судалгааны цогц бүтээл, тусгай үзэсгэлэнг зохион байгуулсан.</p> <p>Мөн хадгалалт хамгаалалтын орчинг сайжруулах, нөхцөл байдалтай нь газар дээр нь Нийслэл Улаанбаатар хотын удирдлага танилцах ажлыг зохион байгуулсны үр дүнд 2020 оноос Нийслэлээс Сарьдагийн хийдийг аялал жуулчлалын бүс болгох анхны санаачилга гаргаад байгаа.</p>	<p>лин хийд мөн болохыг энэ төслийн хүрээнд бүрэн баталгаажуулж чадсан. Нидерландын нарны цаг, Оросын буу, Энэтхэг дэх Монголын эзэнт улсын зоос, Балба, түвэдийн шашны эд зүйлс, Хятадын Мин улсын үеийн шаазан зэрэг дэлхийн 10 гаруй улстай харилцаатай байсныг түүхийн баримт гэрчилж байна. Өөрөөр хэлбэл XVII зууны Монголын хот суурины хөгжил ямар түвшинд байсныг эхний судалгаагаар харуулж байна.</p>
3	Хар Балгас	<p>Булган аймгийн Дашинчилэн сумын нутагт орших хуучны нэгэн хотын туурийг судлаачид Цогт хун тайжийн нэртэй</p>	<p>Харбухын балгас нь Киданы үеийн хэрмийг ашиглаж байгуулсан бөгөөд он</p>

		<p>холбодог. 1970 онд тус хотын тууриас “Үйсэн дээр бичсэн цааз” ном олсон нь дэлхийд шуугиан болж Герман улсад 22 жил сэргээн засварлалт хийсэн болно. Уг үйсэн ном нь Монголчуудын бичиг соёлын одоо байгаа хамгийн анхны эх баримт болж хадгалагдаж байна гэж үздэг.</p> <p>Харин бид энэ төслийн хүрээнд тус хотын туурьд археологич Л.Эрдэнэболд ахлагчтай судалгааны багийг 2018 онд ажиллуулсан. Тус Хар бухын балгасны тухай архивын баримт болон бусад өмнөх үеийн судалгааны эх хэрэглэгдэхүүнийг Монгол улсын болон ОХУ, Польш зэрэг орны архивуудаас хуулбарлан авсан болно. Мөн Харбухын дэвсгэр зургийг орчин үеийн чанарын өндөр төвшинд хийж гүйцэтгэсэн.</p>	<p>цагийн хувьд XVI зууны эцэс XVII зууны эхэн хагасд холбогдох дурсгал бөгөөд өнөөг хүртэл хэд хэдэн малтлага судалгаа явагдсан ч системтэй судалсан, тусгайлан ном бүтээл гарсан зүйл алга байна. Мэдээлэл хангалттай бус гэсэн үг юм.</p>
4	Хөгнө тарна	<p>Булган аймгийн Рашаант сумын нутагт орших Өвгөн хийд буюу Хөгнө тарнийн хийдэд 2017, 2018 онуудад урт богино хугацаагаар малтлага судалгааг анх удаагаа явуулж, агаарын зураг үйлдэв. Хөгнө Тарнийн өвгөн хийд нь хэдийгээр Өндөр гэгээн Занабазартай холбож, халх-ойрадын дайны хөлд сүйдсэн гэж үздэг боловч түүнийг дахин эргэж харах шаардлагатай байгаа нь судалгаагаар тодорхой болж байна. Мөн нөгөө талаараа аялал жуулчлалын гол замын</p>	<p>Хөгнө тарнийн хийдтэй холбоотой аман домгоос өөр зүйл өнөөг хүртэл байхгүй байсан бөгөөд бидний судалгаагаар илүү өргөн хүрээнд мэдээлэлээр хангах, аялал жуулчлалд ашиглах, сэргээж хадгалалт хамгаалалтыг сайжруулахад гол үндэс болох судалгааны ажлуудыг эхлүүлээд байна.</p>

		<p>дагуу боловч өнөөг хүртэл ямар ч судалгаа шинжилгээ хийгээгүй, тайлбар мэдээлэл байхгүй, зөвхөн аман домог төдий явж ирсэн нь ихээхэн өрөөсгөлтэй болохыг бидний судалгааны явцад тодорхой харагдаж байна. Сүмийн ерөнхий зохион байгуулалт нь хот мандалын тэгээр бүтээгдэж, маш гоёмсог ханийн зураг бүхий хийд байжээ гэдэг нь мэдэгдсэн.</p>	<p>Зарим сонирхолтой мэдээлэл Оросын Эртний улсын Архиваас олдсон.</p>
5	Сүмийн толгой	<p>Завхан аймгийн Тэс сумын нутаг Дооно багийн нутагт Тэс голын салаалсан арал дээр орших нэгэн хуучны балгасны туурийг нутгийнхан Сүм толгой хэмээн нэрлэдэг. Бид төслийн хүрээнд 2018 оны 8 сар, 2019 оны 6 сард тус тус хоёр удаагийн малтлага судалгаагаар уг балгас нь ямар нэгэн цэргийн зохион байгуулалт бүхий газар биш бурхны шашны нэгэн томоохон цогцолбор сүм байсан нь бараг мэдэгдэж байна. Малтлага судалгаагаар их хэмжээний үйсэн дээр монгол бичгээр бичсэн судруудын хэсэг, төвд үсгээр бичигдсэн үжирсэн цаасан судрын хэсгүүд, сүмийн зүмбэрлэсэн хээ бүхий багана, дам нуруу зэрэг зүйлс олдохын зэрэгцээ бүтэц зохион байгуулалтын хувьд XVII зууны бусад сүм хийдүүдтэй ихээхэн төслөг байдалтай байна. Сүм толгойд явуулсан судалгаа нь урд өмнө огт судлагдаагүй</p>	<p>Уг хийдийг миний бие Хотогойдын Лувсан Эринчин Алтан хааны дүү анхдугаар дүрийн Жалханз хутагтын үед баригдаж байсан байж магадгүй гэж үзэж байна. Өөрөөр энэ бүс нутагт томоохон нөлөө бүхий хутагт хувилгаад үгүй болно. XVII зууны эхэн үед тус бүс нутагт ирж түр сууж байсан түвэдүүд ийм томоохон нүсэр байгууламжийг байгуулсан гэхэд ихээхэн эргэлзээтэй санагдана.</p>

		<p>бөгөөд нутгийн зон олон ч учрыг нь сайн мэдэхгүй өнөөг хүрчээ. Тиймээс уг сүйдэж үгүй болох магадлалтай уг хийдийн туурийг хэрхэн сэргээх, хадгалах хамгаалах, бүтэц зохион байгуулалт ямар байсан тухай нарийвчилсан сэргээн засварлах зураглал үйлдүүлсэн болно. Уг дурсгалын малтлагаас илэрсэн үйсэн дээрх бүтээлүүд нь Монгол нутгийн умард хязгаараас олдсон анхны тохиолдол бөгөөд Монголын бурхны шашны түүхэнд онцгой байр суурийг эзлэхээс гадна шунхаар бичигдсэн үйсэн номны анхны тохиолдол болно. Ихэнх судлаачид үүнийг Манжийн Зүүнгарыг дайлахын тулд байгуулсан Тэс голын хөвөө дэх цэргийн суурин гэж үздэг үзлийг үгүйсгэхийн ялдамд бурхны шашны хөгжлийн төвшин ямар байсныг тодорхойлчих боломжтой болгосон дурсгал юм. Хотогойдын Алтан хаадтай холбоотой. Оросын анхны элч 1616 онд ирснээс Алтан хаад Оросын харилцаа өргөжиж улмаар Орос, Манжийн харилцаанд Монголчууд томоохон үүрэг гүйцэтгэхэд энэ хот чухал үүрэгтэй байсан.</p>	
2. Хавсарга судалгаа			
1	Хэсэг байшин	Бид XVII зууны хот, сүм хийдийн цогц судалгааг явуулахдаа зөвхөн төслийн хүрээнд заасан газарт бус зарим нэг	Уг дурсгалуудыг малтан судлахад Юань улсын дараахь үед Монголчууд эх

		<p>тухайн үед байгуулагдсан байх магадлалтай хэдэн газарт нэмэлт судалгааг явуулсан юм. Учир нь дээрх сүм хийд, хотуудын түүхийг тодруулах, мөн хадгалах хамгаалах зайлшгүй шаардлага үүсээд байгаа, ижил төстэй харьцуулах шаардлага бүхий хэдэн газрууд байгаагийн нэг нь Хэсэг байшин, Олон байшин хэмээн нэрлэгдсэн Дорноговь аймгийн Их хэт сумын нутаг дахь эртний хотын тууриуд юм.</p> <p>Төслийн хүрээнд 2018, 2019 онуудад тус газруудад малтлага судалгааг Э.Уртнасан удирдаж зохион байгуулсан. Малтлагаар тухайн дурсгалуудын талаар шинээр авч үзэх маш сонирхолтой дурсгалууд илэрч олдсон бөгөөд цөөн тооны үйсэн номны хэсгүүд илэрсэн. Хэсэг байшинг 1923 оны үед Их зохиолч Д.Нацагдорж шинжлэн судалснаас хойш нарийвчлан судалсан хүн бараг үгүй юм. Тиймээс бид говийн бүсийн XVII зууны нэгэн хэсэг хотын туурьд малтлага хийж тухайн үеийн хангайн бүсийн сүм хийд, хот сууринаас ямар онцлогтойг харьцуулан үзэх, цаашид орон нутаг, улсын хэмжээнд хадгалж хамгаалахад шаардагдах зүйлсийг тодруулахыг хүссэн болно. Мөн агаарын зураг үйлдсэн.</p>	<p>нутагтаа буцаж ирээд түр байгуулсан байж магадгүй гэж үзэж байна. Нөгөө талаараа XVII зууны эхэн хагаст Лигдэн хутагт болон манжийн хааны үймээнээс дайжсан өвөр Монголын ноёд бөөгнөрөн сууж байсан байж магадгүй ч гэж үзэж болохоор байгаа бөгөөд уг төслийг хэрвээ дахин үргэлжлүүлвэл малтан судалж болохоор хандлага харагдаж байна.</p>
2	Сүм хөх Бүрд	Өндөр гэгээн Занабазартай холбоотой томоохон сүм хийдүүдийн тоонд	Сүм хөх бүрд нь урьд өмнө огт судалгаанд ороогүй

		<p>Дундговь аймгийн Адаацаг сумын нутаг дахь сүм Хөх бүрд болно. Тус сүмд Л.Эрдэнэболд ахлагчтай баг 2019 онд ажилласан. Эхний шатны малтлага судалгаа, план зураглал, агаарын зураг зэргийг үйлдсэн. Малтлагаар XVII зууны Сарьдаг, Хөгнө Тарна зэргээс илэрдэг шавар бурхадын ижил дурсгал нэлээд илэрсэн бөгөөд уг сүмийн унаган төрхийг эвдэж орон нутаг томоохон хэмжээний барилга байгууламж барьсан нь судалгаагүйгээр ажилласныг харуулж байгаа бөгөөд цаашид хэрхэн хамгаалах төлөвлөгөө, арга зүй юу ч алга байна. Энэ нь урьдчилсан нарийвчилсан судалгаагүй хадгалалт, хамгаалалт, аялал жуулчлалын бүтээгдэхүүн болгох гэж оролдвол ямар хүнд нөхцөлд оруулдагийг эндээс харж болохоор байна. Тийм учраас XVII зууны эдгээр сүм хийд, хот сууринг урьдчилсан томоохон хэмжээний малтлага судалгаа, бүтэц зохион байгуулалт, нуралт үүсэх, жуулчдын хөлд сүйдэж болох аюул зэргийг сайтар анхаарсан ерөнхий төлөвлөлт хийх шаардлагатайг харуулж байна.</p>	<p>бөгөөд томоохон хэмжээний цогц малтлага судалгааг цаашид хийх шаардлагатай болохыг манай судалгаа харуулж байна.</p> <p>Нөгөө талаараа бид агаарын маш нарийвчлалтай дэвсгэр зураг үйлдэж хийсэн бөгөөд цаашид аялал жуулчлалын чиглэлээр ажиллах бол анхаарах олон асуудал байна.</p>
3	Алтан хааны хот	<p>XVII зууны Оросын элчийн тэмдэглэлд үлдэж хоцорсон нэгэн мэдээ бол Хотогойдын Алтан хааны нэгэн суурингийн тухай мэдээ болно. 1916 онд</p>	<p>Хотогойдын Алтан хаан Шолой Убашийн үеийн хотын туурь байж магадгүй гэж үзэж байна.</p>

		<p>анх Оросын элч Василий Тюменцийн ирэхэд Увс нуурын хөвөөнд Алтан хааны өргөө байсан хэмээн тэмдэглэгдсэн байдаг юм. Бид Увс нуурын хойд хэсэг Давст уулын урд талд хайгуул хийж нэгэн хуучны хийдийн маягтай туурийг очиж үзэж танилцсан юм. Уг туурийн хэмжээг авч, агаарын зураг үйлдэж, жижиг дээж авах хэмжээний сорьц болох барилгын материалууд цуглуулсан юм. Энэ судалгаа нь Тэс голын хөвөөнд орших Сүм толгой зэргийн түүхийг тодруулахад ихээхэн чухлын зэрэгцээ Орос-Монголын элчин харилцааны түүх, Увс нуурын сав нутаг дахь аялал жуулчлалыг хөгжүүлэхэд жинтэй хувь нэмэр оруулах боломжтой гэж үзэж байна. Цаашид уг туурийг илүү нарийвчлан үзэж, малтлага судалгааг явуулбал он цаг, бүтэц зохион байгуулалт талаасаа мэдэгдэх боломжтой.</p>	<p>Бид нас тогтоох шинжилгээний дээж авсан бөгөөд цаашид нарийвчилсан хайгуул судалгааг Увс нуурын хойш бие, тэс голын сав нутаг, Дөрөө нуур зэрэгт явуулах шаардлага үүсээд байгаа юм.</p>
--	--	---	---

Бид төслийн хүрээнд төлөвлөсөн Цогт тайжийн цагаан байшин, Сарьдагийн хийд, Сүм толгой, Хөгнө тарна зэрэгт гол судалгаагаа явуулаад Харбалгас, Сүм Хөх бүрд, Хэсэг байшин, Алтан хааны хот зэрэгт хавсарга судалгааг явуулсны ерөнхий тойм ийм байна. Судалгааны үр дүнтэй холбоотой зүйлийг хойно тайланд хавсаргана.

Энэ бүгд нь XVII зууны Монгол нутаг дахь хот сууринг судлах, хадгалах хамгаалах, аялал жуулчлалын бүтээгдэхүүн болгох зайлшгүй шаардлага байгааг судалгааны ажлаар харуулсан. Бид төслийн хүрээнд хээрийн малтлага судалгаа

хайгуул, түүнтэй холбоотой угсаатны зүй, аман түүхийн судалгаа, гадаад, дотоодын архив номын сан, музей, соёлын өвийн бусад байгууллагууд дахь холбоотой зүйлсийг бүрдүүлэх ажлыг цахим мэдээлэлийн сан болгож нийтэд нээлттэй болгосон байна.

2.3.Төслийн ажлыг гүйцэтгэхэд ажлын ерөнхий чиглэл, туршлагыг хэрхэн ашигласан тухай

XVII зууны Монголын хотуудыг цогцоор нь судлах, хадгалалт хамгаалалт хийх, аялал жуулчлалын бүтээгдэхүүн болгоход бидний 2013 оноос эхлэн хэрэгжүүлсэн “*Сарьдаг хийдийн судалгаа*”-ны ажлын туршлага, хийгдсэн ажил, бэлтгэсэн боловсон хүчин ихээхэн чухал үндэс болж өгсөн. Хээрийн малтлага судалгааны ангийг ерөнхийд нь С.Чулуун удирдаж, хээрийн малтлагын талбайн ажлыг археологич Ч.Энхтуул, Э.Уртнасан нар хариуцаж ажилласан. Монголын эзэнт гүрнээс хойших үеийн хот суурины археологи дээр энэ хоёр судлаач нэлээд туршлага хуримтлуулсан нь ажлын ерөнхий туршлага болж байлаа.

Мөн аялал жуулчлалын бүтээгдэхүүн болгох хөтөлбөр боловсруулахад С.Чулууны удирдаж хийлгэсэн “*Цайны замын агуй*” буюу Өмнөговь аймгийн нутагт буй бичээс бүхий агуйг аялал жуулчлалын бүтээгдэхүүн болгон анхны цогц хөтөлбөр боловсруулсан зэрэг туршлагатай. Мөн оролцогч судлаачид нь Монгол улсын түүх, соёлын судалгааны үндсэн үйл ажиллагаа явуулдаг байгууллагаас бүрдэж байгаа бөгөөд судалгаа, хадгалалт хамгаалалт, бүтээгдэхүүн болгох чиглэлээр мэргэшсэн судлаачид багтсан нь ихээхэн сайшаалтай байсан юм.

Хадгалалт хамгаалалтын орчинг сайжруулах, хамгаалалтын нөхцөлийг хэрхэн явуулах зэргийг бид хийхдээ эхлээд барилгуудын бүтэц зохион байгуулалтыг сайтар нарийн хэмжээсээр буулгах, компьютерээр нөхөн сэргээх, уугуул байсан байдлыг холограмм хийж сэргээх зэрэг ажлуудыг гүйцэтгэсэн болно.

Бид Монгол нутагт буй XVII зууны хотуудын нэгдсэн бүртгэлийг дахин үйлдэж, хотуудын зураглал үйлдэж, хот бүрт зохих хэмжээний малтлага судалгааг явуулж, хотын зохион байгуулалт бүтэц, онцлог зэргийг харуулах хэмжээний малтлага ил дурсгалуудыг харуулахаар зохион байгуулж чадлаа.

Үүнийг хийхэд өмнө өөр сүм хийд, хот суурины мэдээлэл дээр ажилласан тусгай мэргэжлийн байгууллагын залуучууд, гадаадын соёлын өвийн сэргээн засварлалтын төв зэргийн хүчийг ашиглаж хийлгэж авсан болно. Аялал жуулчлалын бүтээгдэхүүн болгохын өмнө бид хэрхэн хөгжүүлэх, системтэй авч явах талаар бүхэл бүтэн сургалт, хэлэлцүүлэг, орон нутгийн уулзалт зэргийг зохион байгуулж, аялал жуулчлалын үзэсгэлэн зэрэгт танилцуулга хийсэн.

Томоохон хэмжээний үзэсгэлэнгүүд, жижиг танилцуулга үзэсгэлэн зэргийг хэд хэдэн удаа зохион байгуулсан. Хөтөч нарт тодорхой сургалт явуулж сурталчилсан. Өөрөөр хэлбэл эдгээр хотууд нь өнөөг хүртэл системгүй аялал жуулчлалын золиос болж ирсэн байдлыг цаашид сайтар тунгаан бодох ёстой. Ийм байдлаар удаан үргэлжилбэл удахгүй эдгээр хотын туурь устаж, бас түүхийн хувьд судлах боломжгүй болох аюултай байна. Орон нутгийнхан барилга барихын тулд чулууг нь зөөж, зарим нь малын хашаа хороо болгож, самарчид тонуулчид байнга ухаж төнхөж байгаа нь бидний малтлага судалгааны явцад илэрсэн юм.

Бид XVII зууны Монголын хотуудыг судлах, хадгалах хамгаалах, аялал жуулчлалын бүтээгдэхүүн болгох зорилгоо хэрэгжүүлэхийн тулд хэдэн үе шаттай арга хэмжээг авна. Үүнд:

- Монгол нутагт буй XVII зууны бүх хотуудыг бүртгэлжүүлэх, бодит байдлыг судлан үзэж үнэлэлт өгсөн
- Судалгааны хувьд хамгийн чухал бүх хотуудаа малтан судлах, мэдээлэл цуглуулах, бүтэц зохион байгуулалтыг хийх, агаарын болон дэвсгэр зураг үйлдэх, цаашид судалгааны эх хэрэглэгдэхүүн дээр суурилсан ерөнхий төлөвлөгөөг улс орны хэмжээнд, бүс нутгийн хэмжээнд бүрэн ашиглах материаллаг сан хөмрөг буй болсон
- Судалгааны үр дүнд тулгуурлан хадгалалт хамгаалалтыг явуулж хашаалах, хана хэрмийн бэхэлгээ хийх, танилцуулга хийх, сургалт явуулах, танилцуулга хөтөлбөр хийх төлөвлөгөөг боловсруулсан
- Судалгаа болон хадгалалт хамгаалалтын асуудалд тулгуурлан аялал жуулчлалын бүтээгдэхүүн болгох хөтөлбөр боловсруулж, улсын нэгдсэн аялал жуулчлалын системтэй холбох, аялал жуулчлалын бүсчлэл, тухайн аймаг, орон нутгийн бодлого үйл ажиллагаатай холбон

хөгжүүлэхэд анхаарч нэлээд хэдэн хот сууринг улсын хамгаалалтад оруулах саналыг холбогдох газруудад хүргүүлсэн.

- Тухайн XVII зууны хотууд Монгол улсын аль чиглэлийн замын дагуу болохыг дараахь байдлаас харж болно.

1-р зам. Улаанбаатар-Хөгнө тарнын Өвгөн хийд-Хархорин-Төвхөн хийд

2-р зам. Улаанбаатар- Баяннуурын бунхан-Цагаан байшин-Харбалгас-Өгийнуур-Цэцэрлэг

3-р зам. Улаанбаатар-Тэрэлж-Хагийн хар нуур-Сарьдаг хийд-Бурхан Халдун-Аврага балгас

4-р зам. Улаанбаатар-Бага Газрын чулуу-Сүм хөх бүрд-Өмнөговь

5-р зам. Улаанбаатар-Чойр-Хэсэг байшин-Замын Үүд

6-р зам Улаанбаатар-Завхан-Сүм толгой- Хяргас нуур-Улаангом-Увс нуур-Алтан хааны хот /Газрын зурагт буулгана/

XVII зууны Монголын хотуудыг цогцоор нь судлах-хамгаалах-сурталчлах үйл ажиллагааны хөтөлбөр нь Монголын эдийн засагт орж болох боломжоос гадна бусад салбарын судалгаа, мэдээлэлийн үндэс болох боломжтойг ихээхэн харгалзаж үзсэн болно.

2.4.Төслийн гэрээнд тусгагдсан эцсийн үр дүнг ерөнхийлөн авч үзвэл

- XVII зууны үед хамаарах одоогийн Монгол улсын нутаг дэвсгэрт хамаарах хот суурин, томоохон сүм хийдүүдийн түүхийг цогцоор нь судлах, судалгааны эргэлтэд оруулж **“Монголчуудын хот”**-ын нэгэн үеийн түүхийг судлах малтлага судалгааг цогцоор нь явуулсан. Цогт тайжийн цагаан байшин, Хөгнө тарна, Сарьдаг хийд, Харбухын балгас, Сүм толгой, Хэсэг байшин зэрэг газруудад малтлага судалгааг явуулж, археологийн цогц тайлангууд бичиж, дэвсгэр болон агуурын зургийг үйлдэж, бүтэц зохион байгуулалтыг тодорхой болгосон.
- Монгол нутаг дахь XVII зууны хотуудыг судлах, малтан шинжлэх, аман түүх, бичгийн эх сурвалж, жуулчдийн тэмдэглэл зэрэг олон талаас нь судлан,

холбогдох дурсгалуудаас бүрдсэн музейн тасаг, мэдээлэлийн санг үүсгэх бөгөөд орон нутгийн болон үндэсний хэмжээний мэдээлэл сурталчилгааг хэрэгжүүлж, цогцолбор хөтөлбөрийг боловсруулж “Сарьдагийн хийд” цогц үзэсгэлэнг зохион байгуулж 3 сарын дотор нийт 20.000 орчим үзэгч биечлэн үзэж сонирхов. Мөн дотоод гадаадын архив номын сангаас XVII зууны Монголын хот сууринтай холбоотой архивын баримт, эх хэрэглэгдэхүүн, тайлан зэрэг зүйлсийг бүрэн цуглуулж сан бүрдүүлсэн. Тухайлбал, ОХУ-ын Газарзүйн нийгэмлэгийн архиваас Лисовскийн Сарьдаг хийдийн тухай тэмдэглэл, Эрмитаж Улсын музейгаас 1915 оны орчим аваачсан дурсгалуудаар Ю.И.Элихинагаар дамжуулан эрдэм шинжилгээний өгүүлэл, ШУА-ийн Санкт-Петербургийн салбарын архиваас Цогтын цагаан байшин болон Харбухын балгасын тухай тайлан, тэмдэглэл, дэвсгэр зургуудын материал, Эрхүүгийн тойргын архиваас мөн дээрхтэй төстэй Ядринцев, Клеменц зэргийн тайлангуудыг хуулбарлан авч ирсэн. БНХАУ-ын 1-р архиваас XVII зууны үеийн Улиастай Засагт хантай холбоотой баримтуудыг хуулбарлан авчирсан.

- XVII зууны Монголын хотууд түүхэн гэрэл зураг, баримт, дурсгалын “**XVII зууны Монголын ертөнц ба хот**” каталоги хийх төлөвлөгөөний дагуу “САРЬДАГИЙН ХИЙД: Өндөр гэгээн Занабазарын уран бүтээлийн хүрээ түүх-археологийн судалгааны жишиг каталогийг хэвлэн нийтлүүлэв. Уг бүтээл нь энэхүү төслийн хүрээнд хэвлэгдэж байгаа бүтээл болно. Тус бүтээл нь өмнө манай улсад төдийгүй дэлхийн Монгол судлалын хүрээнд өмнө нийтлэгдэж байгаагүй судалгааны үр дүн болно. Мөн хэд хэдэн хот, сүм хийдийн малтлага судалгаагаар өгүүлэл, эрдэм шинжилгээний илтгэл дэлхийн хэд хэдэн улс орнуудад тавьж хэлэлцүүлсэн болно.

Монголчууд XVII зууны Монголын хот суурины хөгжилд оруулсан хувь нэмэр, түүний онцлог, нүүдэлчид ба суурьшмал соёлын харилцаны түүхийг харуулсан бүтээл болно. Мөн уг бүтээлийг хийхэд цуглуулсан эх материалыг архив бүрдүүлж захиалагч байгууллагад болон ШУА-ийн Түүх, Угсаатны зүйн хүрээлэнгийн түүхийн эх сурвалж, баримт мэдээлэлийн төвийн сан хөмрөгт хүлээлгэн өгөхөд бэлэн болсон байна.

- XVII зууны Монголын томоохон хотууд Сарьдаг хийд, Цагаан байшин, Харбалгас, Сүм хөх бүрд зэргийг хамгаалалтад авхуулж, тусгай хөтөлбөр боловсруулах, орон нутгийн иргэдэд таниулга сурталчилгаа хийх, жуулчдад зориулсан үзүүлэлэг хөтөлбөр боловсруулах, маршрут гаргах зэрэг ажлыг гүйцэтгэсэн бөгөөд дээрх газруудад явуулсан холбогдох гэрэл зураг зэргийг сан хөмрөгт шилжүүлнэ. XVII зууны хотууд гадаад, дотоодын жуулчдыг ирэхэд бүрэн тодорхой мэдээлэл агуулсан, тухайн орон нутагтаа эдийн засгийн үр өгөөжтэй соёлын объект болж чадах ёстой. Тэдгээрийг судалгааны болон олон нийтийн хэрэгцээнд зориулан хийснээр эцсийн бүтээгдэхүүн **“XVII зууны Монголын нүүдэлчид ба хот”** гэсэн ойлголт бүрэн бүрдэж чадах боломжтой болсон гэж үзэж байна.
- XVII зууны Монголын хотуудын талаар эрдэм шинжилгээний **“Монголын нүүдэлчид ба хот”** хэмээх олон улсын эрдэм шинжилгээний хурлыг 2018 оны 8 сарын 29-30-нд Улаанбаатар хотноо зохион байгуулсан бөгөөд оролцогчдын илтгэлийн эмхэтгэл ном болоход бэлэн эмхэтгэл хэвлэгдсэн.

2.5.Төслийг хэрэгжүүлсний үр дүнгийн шинэлэг буюу дэвшилтэт талын тухайд

Уг захиалгат ажлыг хэрэгжүүлснээр хэд хэдэн шинэлэг бөгөөд дэвшилтэд талтай болсон гэж төслийн багийнхан үзэж байна. Үүнд:

- XVII зууны Монголын ертөнцийг тодорхойлох хамгийн боломжтой тухайн үед байгуулагдсан хот суурин, сүм хийдийг цогцоор нь анх удаагаа үндэсний хэмжээнд судалгаа явуулснаар дэлхийн хөгжлийн чиг хандлага дээр Монголын нүүдэлчдийн байр суурь ямар байсныг шууд илэрхийлж чадах, тухайн үеийн олон үсм хийд, хот суурины хөгжлөөр дамжуулан Монголын эзэнт гүрний дараахь үеийн нийгмийг танин мэдэхэд нэн чухал алхам болсон гэж үзэж байна.
- Монголын хот суурингийн дотроос хамгийн бага судлагдсан, үндсэндээ орхигдсон энэ үеийн хот суурин нь Манж Чин улсад орохоос өмнө Монголчууд өөрсдөө хэрхэн хот байгуулалтыг буй болгож, түүнийгээ

- хөгжүүлж байсныг тодорхойлохоос гадна бүс нутгийн харилцаанд гүйцэтгэсэн байдлыг тодруулахад Цогт тайжийн цагаан байшин, Хар бухын балгас, Сүм толгой, Сарьдаг хийд, Хөгнө тарна, Хэсэг байшин, Сүм хөх бүрдэд явуулсан цогц малтлага судалгаа юм. Өмнө манай түүх бичлэг зөвхөн нэр дурддаг байсныг эс тооцвол нарийн судалгаа аль ч дурсгал дээр байгаагүй гэдгийг бид зориуд онцлож байна.
- XVII зууны Монголын хот суурины асуудлыг цогцоор нь авч үзснээр түүнээс гарсан үр дүн, судалгааны тайлан, эх хэрэглэгдэхүүн, архивын болон бусад баримтуудыг нээлттэй үзэх боломж бүрдэхэд нээлттэй мэдээлэлийн сан ихээхэн чухал үүрэг гүйцэтгэх болно. Энэ бол монголын бусад үеийн дурсгалын энэ загвараар судлан шинжлэх хөтөлбөрийг үргэлжлүүлбэл тодорхой хугацааны дараа цогц бүтээл буй болох боломж бүрэн буй болгож байгаагаараа цоо шинэ үр дүн гэж үзэж байна.
 - Монгол нутагт өнөөдрийг хүртэл хадгалагдаж ирээд орчин үеийн хүмүүсийн буруу үйлдэл, санаатай, санамсаргүй байдал, үйлдвэрлэл, хот суурин, байгаль цаг уурын өөрчлөлт зэргээс хамааран сүйдэж үгүй болох магадлал өндөр эдгээр хотуудыг хамгаалах, орчныг сайжруулах, бэхжүүлэхэд энэ төсөл хэрэгжснээр томоохон дэвшил авч ирэхийн зэрэгцээ нутгийн ардыг аялал жуучлал, орон нутгийг сурталчлах, өөрийн өв соёлоо танин мэдэхэд ихээхэн чухал хувь нэмрийг оруулж чадна. Тухайлбал, Завхан аймгийн Тэс сумынхан Сүм толгойг огт хайхардаггүй байсан бол малтлагаас хойш нутгийнхаа чухал соёлын өв хэмээн аймгийн хэмжээнд бүртгүүлж, улмаар аялал жуулчлалын томоохон төв болгоно хэмээн зорьж байхад Дундговь аймгийн Адаацаг сумын Сүм хөх бүрд нь судалгаа шинжилгээ байхгүй өөрийн соёлын өвийг хэрхэн сүйтгэснийг сайтар ойлгож улам засаж залруулах ажлууд эхэлсэн нь төсөлтэй холбоотой.

2.6.Төслийг хэрэгжүүлснээр Монгол улсын эдийн засаг, нийгмийн болон шинжлэх ухаанд гарсан ач холбогдолын тухайд

Тус төслийг хэрэгжүүлснээр Монгол улсад судалгааны түвшинг дээшлүүлэх, цоо шинэ эх баримт судалгаагаар Монголын түүхийн нэгэн үеийн түүхийг тодорхойлох, ач холбогдолыг нэмэгдүүлэх зэрэг шинжлэх ухааны ач холбогдолоос гадна эдийн засаг, нийгэм, танин мэдэхүйн маш өргөн хүрээний ашигтай болсон гэж үзэж байна. Өөрөөр хэлбэл Монголын эзэнт гүрний дараахь археологийн нэгэн цогц судалгаа ШУА-ийн Түүх, Угсаатны зүйн хүрээлэнд хэрэгжсэн байна.

Түүх, соёлын өвийг аялал жуулчлалын бүтээгдэхүүн болгох тухай сүүлийн 10 гаруй жил ярьсан ч хэрэгжүүлсэн зүйл өнөө хир бараг байхгүй. Үүний гол үндэслэл нь шинжлэх ухааны судалгаа явуулалгүй хэрэгжүүлсэнтэй шууд холбоотой. Судалгаа шинжилгээ хийж, түүнийхээ дагуу хадгалалт хамгаалалтаа бүрдүүлж, мэдээллээр хангаж, урт богино хугацааны төлөвлөлт хийж, хэрэгжүүлэх хөтөлбөрөө боловсруулж аялал жуулчлалаа хөгжүүлэх төлөвлөгөөг хийж чадаагүй юм. Өөрөөр хэлбэл “судалгаа-сурталчилгаа” уялдаа холбоогүй байснаас асуудал үүссэн гэж бид үзэж байна. Мөн судалгааны үр дүнд илэрч олдсон, нээгдсэн, зохион байгуулалт нь тодорхой болсон сүм, хот суурины судалгааны баялаг сан хөмрөг нь цаашид монгол улсад бүсчилсэн аялал жуулчлалд цоо шинэ үеийг авч ирэхийн зэрэгцээ маш баялаг эх суурь болж өгч чадна.

Шинэ орчин, шинэ судалгааны эх материалд тулгуурласан зохистой хөтөлбөр нь аялал жуулчлалыг зөвхөн гадныханы хүрээнд биш орон нутгийн хэмжээнд ч санхүүгийн чадамжтай болгох боломж бүрдэнэ. Мөн хот суурины малтлагаас гарсан хосгүй дурсгалуудаар үзэсгэлэн гаргах, ном бүтээл туурвих, сургалт семинар зохион байгуулах зэрэг олон ажлыг гүйцэтгэх боломжтой. Санхүүгийн хувьд орон нутагт болон улсын төсөвт маш тодорхой хэмжээний мөнгө энэ хөтөлбөрөөс шингэнэ. Уг хотын аялал жуулчлалын загварыг бид Солонгосын хаадын ордон болон түүхэн дурсгалт газруудыг холбон хөгжүүлсэн аялал жуулчлалын системийг ихээхэн чухал гэж үзэж нэлээд харьцуулахын зэрэгцээ төслийн хугацаанд хэд хэдэн газартай харилцаатай байсан юм. Хамгийн чухал нь эдгээр хотын туурийн бараг 80 хувийн хажууд ямар нэгэн хэмжээгээр аялал жуулчлалын бааз, томоохон байгалийн цогцолборт газрууд оршиж байна. Энэ бол давуу тал юм. Учир нь хот байгуулах монголчуудын хуучин уламжлал нь байгал

газар зүйн орчинг маш сайн сонгодог байсантай холбоотойг энэ удаагийн захиалгат төсөл хэрэгжүүлсэн гэж үзэж байна.

Нийгмийн хувьд олон түмэн түүх соёлын өвөө хайрлах, хамгаалах, түүндээ хүндэтгэлтэй хандах, бүтээгдэхүүн болгох, түшиглэн үйлдвэрлэл явуулах, инновацийн бүтээгдэхүүн буй болгох, соёлын өвийн дурсгалуудыг хэв загвар ашиглан жуулчны бааз суурин байгуулах, амралт, сувилалын газар байгуулах зэрэг боломж Монголын XVII зууны хотуудын дэргэд бүрэн бүрдсэн. Бид жишээ болгох зорилгоор Сарьдагийн хийдийн малтлага судалгааны үр дүнгээр тусгай бүтээгдэхүүн “брэндбоок” хийж туршсан болно. Эцэст нь XVII зууны Монгол хотууд, хадгалалт хамгаалалт, аялал жуулчлалын бүтээгдэхүүн болох нь төсөл нь Монголын түүхийн маш бага судлагдсан боловч томоохон дурсгалууд хадгалагдаж үлдсэн газруудад түүх-археологийн цогц судалгааг явуулж, судалгааны үр дүнд тулгуурлан аялал жуулчлалын бүтээгдэхүүн болгох, хадгалалт хамгаалалт хийх хөтөлбөр боловсруулж, сан хөмрөг үүсгэсэн явдал нь маш үр дүнтэй болсон гэж ойлгож байна. Тэгэхээр энэ төсөл хэрэгжиж эхлэх нь эдийн засаг, шинжлэх ухаан, танин мэдэхүйн ач холбогдолоос дутахааргүй нийгмийн бүхий л хүрээнд ихээхэн чухал ач холбогдол, үр дүнтэй болсон.

2.7. Үр дүнг шилжүүлэх, борлуулах, ашиглах боломж, төслийн өртгийг нөхөх урьдчилсан тооцоо, хугацаа (бусдад худалдах, лицензийн гэрээгээр ашиглуулах, төсөл, сэдэвт ажлыг санаачлагч өөртөө үлдээх гэх мэт)

Төслийн үр дүнд малтлага судалгааны түүхэн гэрэл зургууд, тайлан, холбогдох эх хэрэглэгдэхүүнийг бид ШУА-ийн Түүх, Угсаатны зүйн хүрээлэнгийн сурвалж судлал, түүхийн баримтын мэдээлэлийн сан хөмрөгт бүрэн хүлээлгэн өгч, захиалагчийг төлөөлж Шинжлэх Ухаан технологийн санд албан ёсоор хүлээлгэж өгөхөд бэлэн болсон байна. Түүнээс гадна ШУА-ийн Түүх, Угсаатны зүйн хүрээлэнгийн цахим хаяг дээр тусгай цонх нээж холбогдох тайлан, гэрэл зургууд, эрдэм шинжилгээний үр дүнг нээлттэй байрлуулснаараа онцлогтой. Цаашид тухайн санг ашиглах, цаашид өргөжүүлэх ажлыг захиалагч байгууллага Соёл, Спорт, Аялал жуулчлалын яам хариуцах бөгөөд үйл ажиллагааг цаашид

үргэлжүүлэх ажлыг төслийн багийнхан хариуцаж ажиллаж байхаар гэрээ байгуулах болно.

3. XVII ЗУУНЫ МОНГОЛЫН ХОТ, СҮМ ХИЙДҮҮДЭД 2017-2019 ОНД ЯВУУЛСАН ҮЙЛ АЖИЛЛАГАА

3.1. Малтлага судалгаа

Хүснэгт 2. Малтлага судалгааны тойм.

№	Малтлага судалгаа явуулсан газар, удирдагч, археологич	Хугацаа	Гарсан үр дүн
1	Сарьдагийн хийд. Төв аймаг. Эрдэнэ сум. С.Чулуун, Ч.Энхтуул	2017.06.24- 2017.07.28	Гол цогчин сүмийн зүүн талд байрлах модон сүмийг малтлаж түвэд хийцийн модон сүмийг малтлахын зэрэгцээ тооно, хаалга зэрэг монгол хийц бүхий зүйлс илэрч олдсон. Нөгөө талаар гол гурван сувраганд малтлага явуулж хамгийн зүүн талын суврагны бүтцийг мэдэж авсан. Уг малтлагыг явуулснаар Сарьдаг хийдэд хийгдэж чадахгүй байсан хамгийн сүүлчийн малтлага судалгаа амжилттай хэрэгжиж судалгааны ажлыг эмхэлж цэгцлэх ажилд бид орсон юм.
2	Хөгнө тарна. Булган аймаг. Рашаант сум.	2017.08-01- 20	Уг сүмд малтлага судалгаа явуулсан нь бараг анхны тохиолдол бөгөөд бүтэц

	Ц.Цэрэндорж. Ч.Энхтуул.	09.13-22	зохион байгуулалтыг мэдэх дэвсгэр зураг үйлдэж агаарын зургийг сайн авсан. Мөн гол сүмийн буланд хэсэг газарт сорьц малтлага явуулсан. 2018 онд малтлаж судлах төлөвлөгөөгөө боловсруулсан. Хоёр удаагаа жижиг хэмжээний малтлага судалгааг явуулсан. Цөөн тооны шавар бурхад, цаца зэрэг зүйлс илэрч олдсон.
3	Цогтын Цагаан байшин. Булган аймаг. Баяннуур сум. С.Чулуун. Ч.Энхтуул.	2017 оны 9 сарын 16-наас 9 сарын 26-нд.	Цогт тайжийн Цагаан байшингийн гол ордон болох их ордоны дээд талд байх зүүн талын жижиг сүмд малтлага судалгааг эхлүүлсэн. Мөн дэвсгэр зургийг шинээр хийж, агаарын зургийг 3D хийсэн. Германы эрдэмтдийг аваачиж малтлага дээр зөвлөгөө авсан. Малтлагаас Мин улсын үед холбогдож болох шаазан аяга, сангийн бойпор, өвөрмөц хэлбэр дүрс бүхий амьтад, уйгур, киданы үеийн бололтой шавар урлалын зүйлс ч мөн илэрч олдсон нь Цогт тайж өвөрмөц шүтлэг бишрэлтэй нэгэн байсныг гэрчилж байна. Зарим сурвалжид түүний шүтлэг бишрэлийг этгээд хэмээн тэмдэглэсэн байдаг нь магадгүй Цагаан байшинг бүтээх үед ойролцоох хуучин уйгур, киданы үеийн хот сууриныг ашиглаж байсан байх магадлалтай гэсэн дүгнэлтэд хүрсэн юм.
4			

	<p>Цогтын Цагаан байшин. Булган аймаг. Баяннуур сум. С.Чулуун. Ч.Энхтуул.</p>	<p>2018 оны 6 сарын 16-наас 27-нд.</p>	<p>Цогт тайжийн гол барилгын бүтэц зохион байгуулалтыг тодруулахын тулд хэрмийн дотор, зүүн хойно хэсэгт байрлах 8.9х6.6 хэмжээтэй сүмийн тасалгаанд матлага судалгааны ажлыг явуулсан. Барилгын дээврийн хэрэгсэлүүд, домгийн амьтдын шавар баримлууд, бурхны шашны холбогдолтой олдворууд илэрч олдсон бөгөөд Монгол-Мингийн үеийн харилцааны түүхэнд холбогдох олон зүйлс илэрч олдсон. Луу ороосон сангийн бойпор, шатсан түвэд үсгийн барын хэв зэргийг энд дурдая. Ямартай ч Цогт тайжийн цагаан байшинд явуулсан дурсгалууд нь тус дурсгалыг цаашид хадгалах, хамгаалах шаардлагатайг илэрхийлэхийн зэрэгцээ аялал жуулчлалын мэдээлэлийн төв байгуулах, барилгыг сэргээн босгоход бидний судалгааны үр дүн зохих суурь нь болж өгнө. Цг барилгыг тэр хэмжээгээр нь хамгаалалтад авахгүй бол тун удахгүй сүйдэж мэдэхээр байгааг салбарын яам, орон нутгийн засаг захиргаанд албан ёсоор мэдэгдсэн.</p>
5	<p>Хөгнө тарна. Булган аймаг. Рашаант сум. Ц.Цэрэндорж.</p>	<p>2018 оны 6 сарын 28-наас 7</p>	<p>Хийдийн барилгын бүтэц зохион байгуулалтыг тодруулах, тодорхой нэг хэсэгт тогтож малтах зорилгоор барилга</p>

	Ч.Энхтуул.	сарын 10-нд.	<p>№1-ийг тойрсон олон тасалгааны нэг, барилга №2-ийн хойморийн тасалгаа, барилга №6-д тус тус малтлага хийхэд бурхны шашны цөгц зэрэг эдлэл хэрэгсэл, ногоон өнгийн паалантай ваарны хагархай, дугуй хэлбэрийн хавтгай шавар бурхан, төмөр хадааснууд зэрэг Сарьдагийн хийдээс гардаг зүйлстэй нэлээд төслөг зүйлс олдсон юм. Энэ нь уг хийдийг Өндөр гэгээн Занабазартай холбон тайлбарладаг байсныг давхар батална. Харин барилга №2-ийн хоймор хэсгээс өнгө алаглуулан зурсан ханийн зураг илэрч олдсон нь ихээхэн чухал байв. Хэрвээ хөгнө тарна Өндөр гэгээн Занабазарын байгуулсан хийдүүдийн нэг мөн бол ханын зураг бас тухайн үеийн сүм хийдүүдэд хийгдэж байсныг энэ удаагийн малтлага сануулсан. Хөгнө тарнийн хийд нь XVII зууны үед байгуулагдсан хот мандалын бүтэц зохион байгуулалттай өвөрмөц бас нэлээд нүсэр томоохон хийд байсан нь мэдэгдэж байна. Бид уг хийдийн туурийг хэрхэн хамгаалах, аялал жуулчлалын бүтээгдэхүүн болгоход юуг анхаарах тухай хөтөлбөрт тусгасан.</p>
6	Хэсэг байшин. Дорноговь аймаг. Их хэт	2018 оны 7 сарын 27-	1923 оноос хойш анх удаагаа системтэй малтлага хийгдсэн бөгөөд бид эхлээд уг

	<p>сум. С.Чулуун, Ч.Энхтуул</p>	<p>ноос 8 сарын 18-нд</p>	<p>дурсгалын дэвсгэр зургийг үйлдсэн. Түүний дараа малтлага хийгдэж малтлагаар 15-17 зууны үед хамаарч болох нэлээд сонирхолтой дурсгалууд илэрч олдсон. Тухайлбал, сийлбэртэй ясан эдлэл 3 ш, хөх өнгийн шаазан ваар нэг бүтэн, ясан шатар 5 ш, чулуун хүжний суурь, барилгын дээврийн хэрэгсэл гэх мэт зүйлс илэрснээс гадна тус гол барилгын шүншиг торгон ороосон мөнгөн аягатай зүйлс илэрч олдсон юм. Бид уг дурсгалуудыг соёлын өвийн үндэсний төвд сэргээн задлуулсан бөгөөд мөнгөн аяга нь Юань улсын үеийнх болох нь тодорхой болсон бөгөөд дотор нь будаа үр тариа, 9 эрдэнийн зүйлс, эрдэнийн чулуун гахайг дүрслэн хийсэн байв. Бидний үзэж буйгаар уг хотын туурь нь 17 зууны үеийн Өвөр Монголын ноёдууд байгуулсан гэхээс илүүтэй 14 зууны сүүл үед умар тийш нүүсэн Юань улсын цэргүүд хожим энэ хавьд нутагшин сууж байхдаа байгуулсан болов уу гэсэн таамаг дэвшүүлээд байгаа юм. Хэрвээ уг таамаг үнэний хувьд болбол хожим Өвөр Монголын ноёд цугларан сууж байхад Хэсэг байшингийн бичээсийг босгосон гэсэн таамаг уг судалгаагаар хийгдээд байгаа билээ.</p>
7			

	Сүм толгой. Завхан аймаг. Тэс сум. С.Чулуун, Э.Уртнасан, Ч.Энхтуул.	2018 оны 8 сарын 26-29-нд	Завхан аймгийн Тэс сумын нутаг дахь уг хуучин хотын туурийг малтан судлах ажиллагаа өнөөг болтол огт явагдаагүй бөгөөд төслийн удирдагч С.Чулууны мэдээлэлээр 2009 онд А.Очир тэргүүтэй хүмүүс очиж дэвсгэр зураг үйлдсэн. Бид энэ удаад дэвсгэр зураг дахин шалгаж үйлдээд гол барилгын хоймор хэсэгт сорьцын малтлага судалгааг явуулсан юм. Гэтэл монгол бичгээр бичигдсэн үйсэн номны хэсэг 20 гаруй илэрч олдсон юм. Энэ нь уг дурсгалыг цэргийн зориулттай бус шашны зориулалттай байж магадгүй гэсэн таамаглал буй болгосон юм. Дахин малтлахаар төлөвлөж үлдээсэн.
8	Алтан хааны хот. Увс аймаг. Давст сум. Торхилогийн гол.	2018 оны 8 сарын 29-нөөс 9 сарын 2-нд.	Хотогойдын Алтан хаан шолой Убашийнд ирсэн Оросын элчийн тэмдэглэлд тэмдэглэгдэж үлдсэн нэгэн хотын туурийг Увс нуурын савд хайсан боловч бидэнд тоймтой юм олдоогүй. Харин Давст сумаас зүүн тийм Торхилогийн голын ойролцоо нэгэн хуучин шороон хэрэм хэдэн баганын чулуу бүхий газрыг олж үзсэн юм. Бид дэвсгэр зураг үйлдээд, дээж авах модны хэсэг авсан.
9	Сүм толгой. Завхан аймаг. Тэс сум.	2019 оны 6 сарын 2-	Сүм толгойн нийт барилгуудад дэвсгэр зураг үйлдэж, гол барилгад мэргэжлийн

	С.Чулуун, Ч.Энхтуул, Э.Уртнасан.	ноос 22-нд	байгууллагынхантай хамтран 3D нарийн хэмжилт хийж барилга №1-4-т бүтэн болон сорьцын малтлага судалгааг явуулав. Гол барилга болох №1-т бараг бүрэн цэвэрлэгээг хийж барилгын бүтэц зохион байгуулалт, зориулалт зэргийг мэдэж авсан. Барилга нэгийн гол танхимаас үйсэн дээр бичсэн номны хэсэг 100 гаруй, цөөн тооны түвэд бичээс бүхий үжирсэн цаасны өөдөс, сүмийн барилгын нэг дам нуруу, нэг багана бүтэн олдсон. Уг барилга нь бүтэц зохион байгуулалтын хувьд түвэд хийцийн болов уу гэж бид эхний удаад таамаглаж байна. Харин доор байх гол барилгад зүсэлт хийхэд Сарьдаг зэрэг 17 зууны гол цогчин дуганатай ихээхэн төстэй барилга болох нь мэдэгдсэн. Үүнээс үзвэл уг Сүм толгойн дурсгал нь цэргийн суурин бус томоохон нөлөө бүхий шашны төлөөлөгчийн байгуулсан байж болох хийдийн нэг гэж үзэж болохоор байна. Бидний эхний удаад таамаглаж байгаагаар Хотогойдын Омбо-Эрдэнэ Алтан хааны хөвгүүн анхдугаар дүрийн Жалханз хутагтын үед байгуулагдсан болов уу гэсэн таамаг дэвшүүлээд байна.
10	Сүм Хөх бүрд. Дундговь аймаг. Адаацаг сум.	2019 оны 7 сарын 19-	17 зууны үеийн говийн бүсийн хэд хэдэн хот, сүм хийдийн нэг нь Сүм Хөх бүрд

	Л.Эрдэнэболд, Ч.Энхтуул.	нөөс 26-нд.	юм. Уг дурсгалд тусгайлсан судалгаа өнөөг хүртэл хийгдээгүй бөгөөд Цогт тайжийн нүүдэлтэй уялдуулан домоглох ярианаас өөр зүйл бараг үгүй. Харин бид уг төслийн хүрээнд малтлага явуулж үзэхэд Сүм Хөх бүрд нь бурхан шашны зориулалтаар ашиглаж байсан төдийгүй Сарьдаг, Хөгнө тарна зэргээс гардагтай төстэй шавар бурхад нэлээд олдсон нь ихээхэн сонирхолтой. Мөн тухайн дурсгалыг хамгаалах нэрээр урьдчилсан судалгаа хийлгэлгүй унаган байдлыг алдагдуулсан барилга барьж зарим дурсгалуудыг сүйтгэсэнийг бид орон нутаг болон холбогдох байгууллагуудад хандаж анхааруулсан. Цаашид нарийн судалгаа шинжилгээний ажил хийж түүнд үндэслэн мэдээлэлийн төв байгуулах, аялал жуулчлалын цогцолбор байгуулах асуудлыг шийдвэх ёстой юм.
11	Олон байшин. Дорноговь аймаг. Их хэт сум. С.Чулуун, Э.Уртнасан.	2019 оны 8 сарын 21-нээс 9 сарын 4-нд	Говийн бүсийн 17 зууны үед хамаарах хот суурины дурсгалд Хэсэг байшингаас нэг холгүй орших Олон байшин хэмээх газрыг дурдая. Олон байшинд Монголын археологийн түүхэнд судалгаа огт явуулаагүй бөгөөд он цагийн хувьд чухам аль үед хамаарах, бүтэц зохион байгуулалт ямар болох зэргийг тодруулах зорилгоор 2019 онд

			ажилласан. Олон байшингийн ерөнхий дэвсгэр зургийг үйлдэхийн зэрэгцээ, агаарын зураг үйлдэж, нэг сувраганд тусгайлсан малтлага хийсэн. Малтлагаар 10 гаруй тооны үйсэн дээр бичсэн монгол бичгийн дурсгал, ваартай шүншиг зэрэг илэрсэн бөгөөд он цагийн хувьд 17 зууны дурсгал болох нь бараг тодорхой болсон. Тиймээс цаашид 17 зууны хот суурины хөгжилд оруулсан хувь нэмрийг тодорхойлох, бусад дурсгалуудад малтлага судалгааг системтэй явуулах, говийн бүсийн аялал жуулчлалд хэрхэн зохистой зөв ашиглах зэргийг тодорхойлоход нэлээд өргөн хэмжээний малтлага судалгааг явуулахаар бид төлөвлөөд байна.
--	--	--	---

3.2. Сурталчилгаа, танин мэдэхүйн үйл ажиллагаа

Хүснэгт 3. Сурталчилгаа, танин мэдэхүйн үйл ажиллагаа.

№	Үзэсгэлэнд оролцсон байдал	Хаана, хэзээ	Тайлбар
1	Уран бүтээлч Х.Хадхүүгийн “Үлэмжийн чанар” үзэсгэлэн. Сарьдагийн язгуурын 5 бурхан.	Богд хааны ордон музей. 2017 оны 10 сарын 21-31	Өндөр гэгээн Занабазарын уран бүтээлийг орчин үед шаазангаар үйлдэн тусгай үзэсгэлэн гаргахад язгуурын 5 бурхныг төлөөлөл болгон оролцуулсан.
2	“Шинжлэх ухаан, Инноваци-2017” үзэсгэлэн	Уран зургийн галларей. 2017	Жил бүр зохион байгуулагддаг Шинжлэх

		оны 11 сарын 26-наас 27.	ухааны ажилтны өдөрт зориулсан тусгай үзэсгэлэнд оролцсон.
3	“Оюу толгой” ХХК-ны гүний уурхайд “Үлэмжийн чанар” үзэсгэлэн	2018 оны 3 сарын 17-18 Оюу толгой ХХК-ны гүний уурхай	“Оюу толгой” ХХК-ны гүний уурхайд тусгай үзэсгэлэн гаргахад Сарьдагийн язгуурын бурхадыг оролцуулав. 17 зууны Монголын хотууд төслийн хүрээнд уг малтлага судалгаагаар илэрсэн дурсгалуудыг олон түмэнд зөв таниулах, сурталчлах, сэргээн засварлах болон судалгаанд зардал санхүүжилтийн дэмжлэг үзүүлэх зэрэг зорилгоор үзэсгэлэнд оролцсон.
4	“Сарьдагийн хийд” тусгай үзэсгэлэн	2019 оны 9 сарын 27-ноос 12 сарын 24 хүртэл. Монголын Үндэсний музей	Уг төслийн хүрээнд хийгдсэн цогц үзэсгэлэн нь Халхын Өндөр гэгээн Занабазарын 1654-1686 оны хооронд байгуулсан Номын Их хүрээ буюу Сарьдагийн хийдэд явуулсан 6 жилийн малтлага судалгааны үр дүнгээр анх удаагаа Монгол Улсад гарч буй томоохон хэмжээний үзэсгэлэн болсон юм. Энэхүү үзэсгэлэнд тусгайлан сүмийн цогчин сүмийг ямар байсныг

		<p>харуулахыг зорьсон бөгөөд баримтад кино, холограмм, 3D сэргээлт, түүх-археологийн судалгааны каталоги, бэлэг дурсгалын инновацийн бүтээгдэхүүнүүд, уран зураг, аннимишн зэрэг 20 орчим төрлийн төрөл зүйлээс бүрдсэн үзэсгэлэн болсон билээ. Энэхүү үзэсгэлэнгийн нээлтэд Монгол Улсын Ерөнхий сайд болон Ерөнхийлөгч х.Баттулга, ШУА-ийн ерөнхийлөгч Д.Рэгдэл нарын нийт 20.000 гаруй мянган үзэгчид энэ хугацаанд үзэж танилцсан.</p>
--	--	--

3.3. Эрдэм шинжилгээний ном өгүүлэл, илтгэл

Ном:

1. САРЬДАГИЙН ХИЙД: Өндөр гэгээн Занабазарын уран бүтээлийн хүрээ. Ерөнхий редактор С.Чулуун. УБ., 2019.

Өгүүлэл:

1. С.Чулуун, Ч.Энхтуул. “XVII зууны Монголын хотууд төсөл: Сарьдагийн хийд, Өвгөн хийдийн малтлага судалгааны ажлын урьдчилсан үр дүнгээс”-//Монголын археологи-2016. УБ., 2017. тал 263-267.
2. С.Чулуун. Очирт сэцэн хаанд холбогдох тод үсгийн нэгэн захидал. //Ойрад судлал. Будапешт. Эрхлэсэн Агнеш Бирталан, Эрдэмт. 2017.
3. С.Чулуун, Ч.Энхтуул.“XVII зууны Монголын хотууд” төслийн 2017 оны хээрийн судалгааны товч үр дүнгээс //Монголын археологи-2017. Эрдэм шинжилгээний хурал. УБ.,2018, Тал 141-145.
4. S.Chuluun. “In Search of the Khutugtu’s Monastery: The Site and Its Heritage” //The University of Hawai’i Press. 2019. USA. pp.
5. С.Чулуун. Монголын хойд бүс дэх хийдийн туурийн малтлага судалгаа. //Heritage and Culture of the Mongols: Archeological and Literary Monuments. Seoul. тал. 355-362.
6. С.Чулуун, Ч.Энхтуул, Э.Уртнасан. Өндөр гэгээн Занабазарын уран бүтээлийн ордон: Сарьдагийн хийдийн тухай судалгаа. //Хот байгуулалтын түүхэн үйл явц:өнгөрсөн, одоо, ирээдүй. *Илтгэлийн эмхэтгэл. Эрхэлсэн Б.Пунсалдулам.* УБ., 2019. Тал.19-44.

Илтгэл:

1. С.Чулуун., Ч.Энхтуул. Мартагдсан хутагтын хийд: өв, соёл. //Монгол Улсаас Англи улсад суух элчин сайдын яаманд уншсан лекц. 2017 оны 10 сарын 28.
2. С.Чулуун. Сарьдагийн хийдийн малтлага судалгааны тухай анхны үр дүн. //Кембрижийн Их сургууль. 2017 оны 10 сарын 25.
3. С.Чулуун. Түүхийн сурвалж бичиг ба археологийн дурсгалын харьцуулалт: *Анхдугаар дүрийн Жавзундамбын түүх.* //БНХАУ-ын Бээжин дэх Төвийн Үндэстний Их сургууль. 2017.11.4-6. Бээжин.
4. С.Чулуун. Цогт тайжийн тухай домог: үзэл ба ойлголт. //Өвөр Монголын аман зохиолын анхдугаар их хурал. 2017.12.09-11. Хөх хот

5. С.Чулуун, Ч.Энхтуул. *XVII зууны Монголын хот суурины урьдчилсан судалгаа*// “Нүүдэлчид ба хот суурин” олон улсын эрдэм шинжилгээний хурал.Улаанбаатар.2018.08.24-25.
6. С.Чулуун. *“Сведения о новонайденных фрагментах на бересте из Монголии”*// Круглый стол “Тюрко-монгольский мир в рукописях и документах”.V монголоведные чтения, 28 ноября 2018 г.,состоявший в рамках Международного форума “Россия и Восток. К 200-летию российского академического востоковедения”. Санкт-Петербург, Россия. 2018.
7. S.Chuluun and Ch. Enkhtuul. About the archaeological excavations and research carried out Süm Tolgoi. //Mongolian Buddhism: tradition and innovation. 25-26 April. 2019. Budapest.
8. С.Чулуун. Монголын хойд бүс дэх хийдийн туурийн малтлага судалгаа. //Heritage and Culture of the Mongols: Archeological and Literary Monuments. 09-10 November Seoul. 2019.

Тайлангууд:

1. Булган аймгийн Хашаант сумын нутаг дахь Эрдэнэхамбын дээд хийд буюу “Өвгөн хийд”-ийн туурьд явуулсан археологийн малтлага судалгааны тайлан. Ц.Цэрэндорж, Ч.Энхтуул. 2017.
2. Булган аймгийн Баяннуур сумын нутаг дахь Цогтын Цагаан байшингийн туурьд явуулсан археологийн малтлага судалгааны ажлын тайлан. С.Чулуун, Ч.Энхтуул. 2017.
3. Төв аймгийн Эрдэнэ сумын нутаг дахь Сарьдагийн хийдэд явуулсан археологийн малтлага судалгааны ажлын тайлан. С.Чулуун, Ч.Энхтуул. 2017.
4. Булган аймгийн Хашаант сумын нутаг дахь Эрдэнэхамбын дээд хийд буюу “Өвгөн хийд”-ийн туурьд явуулсан археологийн малтлага судалгааны тайлан. Ц.Цэрэндорж, Ч.Энхтуул. 2018.
5. Булган аймгийн Баяннуур сумын нутаг дахь Цогтын Цагаан байшингийн туурьд явуулсан археологийн малтлага судалгааны ажлын тайлан. С.Чулуун, Ч.Энхтуул, Б.Батцоож. 2018.

6. Увс аймгийн Давст сумын нутаг дахь Булгийн хүрээ буюу “Алтан ханы орд”-ын туурьт явуулсан археологийн малтлага судалгааны ажлын тайлан. С.Чулуун, Ч.Энхтуул, Э.Уртнасан. 2018.
7. Завхан аймгийн Тэс сумын нутаг дахь Сүм толгойн туурьт явуулсан археологийн малтлага судалгааны ажлын тайлан. С.Чулуун, Ч.Энхтуул, Э.Уртнасан. 2018.
8. Дорноговь аймгийн Их хэт сумын нутаг дахь Хэсэг байшингийн туурьт явуулсан археологийн малтлага судалгааны тайлан. С.Чулуун, Ч.Энхтуул. 2018.
9. Дундговь аймгийн Адаацаг сумын нутаг дахь Сүм хөх бүрд туурьт явуулсан археологийн малтлага судалгааны ажлын тайлан. С.Чулуун, Л.Эрдэнэболд, Ч.Энхтуул. 2019.
- 10.Завхан аймгийн Тэс сумын нутаг дахь Сүм толгойн туурьт явуулсан археологийн малтлага судалгааны ажлын тайлан. С.Чулуун, Ч.Энхтуул, Э.Уртнасан. 2019.
- 11.Дорноговь аймгийн Их хэт сумын нутаг дахь Олон байшингийн туурьт явуулсан археологийн малтлага судалгааны тайлан. С.Чулуун, Э.Уртнасан. 2019.

3.4. Бусад төлөвлөгөөний дагуу хийгдсэн ажил

Хүснэгт 4. Бусад төлөвлөгөөт үйл ажиллагаа.

№	Хийгдсэн ажил	Хугацаа	Тайлбар
1	“Монголын нүүдэлчид ба хот суурин” Олон улсын эрдэм шинжилгээний хурал	2018 оны 8 сарын 24-25 Улаанбаатар хот	Энэхүү захиалгат төслийн хүрээнд хийгдэх нэг гол ажил бол Монголын нүүдэлчид ба хот суурин хэмээх олон улсын эрдэм шинжилгээний хурлыг Монгол улсад зохион байгуулах явдал байв.
2	Мэдээлэлийн	2017-2020	17 зууны Монголын хот суурины талаарх

	нэгдсэн сан	оны хооронд	судалгааны ажлыг нийтэд нээлттэй болгох, олон улсын Монголч эрдэмтэд, энэ чиглэлээр ажиллаж буй хүмүүсд судалгааны үр дүнг танилцуулах зорилгоор мэдээлэлийн нэгдсэн санг үүсгэсэн. Уг мэдээлэлийн санд 2017-2019 оны хооронд явуулсан 11 удаагийн хээрийн малтлага судалгааны ажлын тайлан, холбогдох гэрэл зургууд, дотоод гадаадын архив, номын сан, музейгээс цуглуулсан эх хэрэглэгдэхүүнүүд, мөн эдгээр хот, сүм хийдийн тухай өгүүлэл, бусад судлаачдын бүтээлээс багтаасан. Цаашид 17 зууны Монголын хот, сүм хийдүүдийг аялал жуулчлалын бүтээгдэхүүн болгох, хадгалалт хамгаалалтыг сайжруулах, орон нутгийн болон улсын хэмжээнд хэрхэн ашиглах талаар хөтөлбөр боловсруулсныг тавьсан.
3	Архивын баримт, эх хэрэглэгдэхүүн цуглуулсан	2017-2019 оны 12 сар хүртэл	17 зууны Монгол нутаг дахь хот, сүм хийдийн холбоотой архивын баримт, эд өлгийн зүйлс дотоод, гадаадын архив номын санд хадгалагдаж буй зүйлсээс бид эрж хайж олж цуглуулах ажлыг өөрсдийн боломжийн хэмжээнд хийгээд байна. Тухайлбал, ОХУ-ын Эрмитаж улсын музейн сан хөмрөгт 1916 оны орчим аваачсан бололтой Сарьдагийн хийдийн эд өлгийн зүйлс, жижиг бурхадын хэсэг гээд нэлээд зүйлс

			<p>хадгалагдаж байгааг илрүүлж тус музейн ажилтан, доктор Ю.И.Елихинагаар Эрмитаж дахь Сарьдагийн хийдийн олдворууд эрдэм шинжилгээний өгүүлэлийг бичүүлж авсан. Мөн БНХАУ-ын Бээжингийн 1-р архивт хадгалагдаж буй Улиастайн жанжны холбоотой 100 гаруй хуудас материалыг хуулбарлаж, ОХУ-ын ШУА-ийн Санкт-Петербургийн салбарын архив, Москва дахь Эртний улсын архив, Эрхүүгийн тойргийн архив, Минусинскийн орон нутаг судлах музейн архив, Тувагийн орон нутгийн архив, Польшийн Краковын ШУА-ийн салбарын архив зэрэгт ажиллаж холбогдох баримт материалуудыг хувилж авсан.</p>
4	Сэргээн засварлалт	2017 оны 7 сараас 2019 оны 8 сар хүртэл	<p>Сарьдагийн хийдийн туурь, Цогтын цагаан байшингийн туурийн малтлага судалгаагаар илэрсэн 300 шахам олдвор хэрэглэгдэхүүнийг малтлагын талбайд цэвэрлэх, сэргээн засварлах, стандартын дагуу савлан тээвэрлэлтэд бэлтгэх зэрэг ажлыг Н.Нандинцэцэг хийж гүйцэтгэв. Төв аймгийн Эрдэнэ сумын нутаг дахь Сарьдагийн хийдийн малтлага судалгаагаар илэрсэн <i>Язгуурын таван бурхан, найман тахил, ахуйн хэрэглээний ваар сав, тагш, шашны шавар эдлэлүүдийг сэргээн засварласнаар</i> анхдугаар Богд Өндөр</p>

			<p>гэгээн Занабазарын урласан бүтээл болохыг баталсан. Түүнчлэн үндэсний экспедицийг амжилттай зохион байгуулж, шинжлэх ухааны чухал үр дүнд хүрч болохыг батлахын сацуу тухайн олдворыг нөхцөл байдалд нь тохируулан сэргээн засварлах, хадгалж хамгаалах ажлыг бүрэн гүйцэтгэх боломжтойг харуулж байна. Түүнээс гадна Завхан аймгийн Тэс сумын нутгаас илэрч олдсон үйсэн болон цаасан суурьтай зарим дурсгалуудыг БНСУ-ын Соёлын өвийн Үндэсний хүрээлэнд шилжүүлэн засварлах ажлыг гүйцэтгэж байна. Цаасан суурьтай уг дурсгал нь бурхан шашны хэдий боловч он цагийн хувьд 16 зууны эцэс 17 зууны эхэн үед хамаарах боломжтой гэж үзэж байна.</p>
5	<p>XVII зууны хот суурин, сүм хийд: <i>аялал жуулчлалын менежментийн төлөвлөгөө</i></p>		<p>XVII зууны хот, сүм хийдийн уг төслийн хүрээнд хийгдэх хамгийн чухал ажлын нэг нь малтлага судалгаа дээр үргэлжлүүлэн аялал, жуулчлалын хөтөлбөрийг боловсруулах ажлыг бид боловсруулсан.</p>
6	<p>XVII зууны Монголын хот суурингууд: <i>хадгалалт, хамгаалалтын</i></p>		<p>XVII зууны Монголын хот, сүм хийдийн судалгааг явуулсны дараа эдгээр дурсгалт газруудыг хэрхэн хамгаалах, хамгаалалтын төлөвлөгөө зэргийг багтаасан хамгаалалтын хөтөлбөр</p>

	<i>төлөвлөгөө</i>		<p>боловсруулсан. Уг хөтөлбөр нь түүх соёлын дурсгалыг хадгалах, хамгаалах, сэргээн засварлах хууль, журмын хүрээнд хэрхэн хэрэгжүүлж болох тухай асуудлыг шинжлэх ухааны үндэслэлтэй боловсруулахыг зорьсон.</p>
--	-------------------	--	---

4. Дүгнэлт

XVII зууны Монгол нутагт байгуулагдсан хот суурин, сүм хийдийн судалгаа, түүнийг хамгаалах, хадгалах, аялал жуулчлалын бүтээгдэхүүн болгох чиглэлээр хэрэгжүүлсэн төслийн хэрэгжилтэд тулгуурлан дараахь хэдэн саналыг дүгнэлт болгохыг зорьсон болно. Үүнд:

- XVII зууны Монголын түүх, соёл, нийгмийн харилцааны асуудлыг судлах эх сурвалж бидэнд өнөөг хүртэл нэн ховор үлдэж хоцорсон бөгөөд тус төслийг хэрэгжүүлснээр тухайн үеийн нийгмийн бүхий л хүрээг хамарсан цогц судалгааг явуулах боломж нээгдэж байна гэж үзэж байна. Өөрөөр хэлбэл, хот, сүм хийдийн судалгааг системтэй өргөн хүрээнд, олон шинжлэх ухааны уулзвар дээр хэрэгжүүлснээр өгүүлэн буй үеийн нийгэм, улс төр, соёл, аж ахуй, гадаад харилцааны олон асуудлыг бодит эд өлгийн баримтад тулгуурлан судлан XVII зууны түүхийг ямар нэгэн хэмжээгээр шинээр бичих боломжийг олгож байна.

- Энэхүү төслийг хэрэгжүүлснээр Монгол нутагт олон зууны туршид зөвхөн аман уламжлалаар улбаалан өнөөг хүрсэн дурсгалт газруудын он цаг, насыг илүү шинжлэх ухаанч бодит байдлаар тогтоох, байгуулсан эздийг тодорхойлох, бүтэц зохион байгуулалтыг тодруулах зэрэг нарийвчилсан малтлага судалгааны ажлыг бичгийн эх сурвалж, эх хэрэглэгдэхүүн, аман түүхийн мэдээ баримтаар баяжуулан 10 гаруй хотоос 8 хот, сүм хийдийг малтан судалсан байна. Энэ нь өгүүлэн буй үеийн хот суурины судалгаанд урьд өмнө хийгдээгүй томоохон хэмжээний ажил болно.
- Хот, сүм хийдийн малтлага судалгаа явуулж, мэдээлэл, баримт эх хэрэглэгдэхүүн хангалттай цуглуулсны зэрэгцээ цаашид эдгээр түүх соёлын дурсгалуудыг хадгалах, хамгаалах, сэргээн засварлах хөтөлбөрийг боловсруулж, холбогдох орон нутаг, салбарын яам зэрэг газруудад танилцуулга хийх, албан ёсны төлөвлөгөөг бэлтгэж өгсөн ба дотоод, гадаадын зорин очсон иргэдэд үнэн зөв мэдээлэл өгч, түүхэн ач холбогдолыг нь ойлгуулж, хайрлаж хамгаалах ажлыг шат дараалалтай зохион байгуулах шаардлага байна.
- Төслийн хүрээнд малтан судалсан дурсгалуудыг хадгалах хамгаалах хөтөлбөр боловсруулахаас гадна аялал жуулчлалын бүтээгдэхүүн болгох, инновацийн бүтээгдэхүүн гаргах, олон түмэнд зөв ойлголт өгөх, гадаад дотоодын аялагчдад ойлгомжтой мэдээлэлээр хангах, унаган төрхийг нь алдагдуулахгүй аялал жуулчлалд ашиглах, урт богино хугацааны хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх саналыг дэвшүүллээ.
- Уг төслийн гэрээнд тусгагдсан XVII зууны үеийн хотуудын цогц малтлага судалгаа явуулж тайлан бичих, мөн хотуудын хамаатай мэдээлэлийн сан бүрдүүлэх, Монголын ертөнц ба хот каталоги (САРЬДАГИЙН ХИЙД: *Өндөр гэгээн Занабазарын уран бүтээлийн хүрээ*. Редактор С.Чулуун. 2019. Тал.500) бүтээл, “Монголын нүүдэлчид ба хот суурин” олон улсын эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл зэргийг бүрэн хийж гүйцэтгэсэн. Цаашид энэ чиглэлийн судалгааг илүү өргөн хүрээнд улс орны хэмжээнд үндэсний хөтөлбөр болгон хэрэгжүүлж, судалгаанд хамрагдсан хот, сүм хийдүүдийг хадгалж хамгаалж, томоохон мэдээлэлийн төвүүд байгуулж,

аялал жуулчлалын цогцолборуудыг байгуулж, сэргээн засварлах шаардлагатай байна.

ХАВСРАЛТ

Эрдэм шинжилгээний тайлангууд

2017 он

1. С.Чулуун, Ч.Энхтуул, Н.Нандинцэцэг. Төв аймгийн Эрдэнэ сумын нутаг дахь **“Сарьдагийн хийд”**-ийн туурьт явуулсан археологийн малтлага судалгааны ажлын тайлан . УБ.,2017 он. Тайлан, хавсралт гэрэл зургийн хамт 94 хуудас.
2. С.Чулуун, Ч.Энхтуул, Б.Батцоож, Н.Нандинцэцэг. Булган аймгийн Баяннуур сумын нутаг дахь **“Цогтын цагаан байшин”**-гийн туурьт явуулсан археологийн малтлага судалгааны ажлын тайлан. УБ.,2017 он. Тайлан, хавсралт гэрэл зургийн хамт 116 хуудас.
3. Ц.Цэрэндорж, Ч.Энхтуул. Булган аймгийн Рашаант сумын нутаг дахь Эрдэнэхамбын дээд хийд буюу **“Өвгөн хийд”**-ийн туурьт явуулсан

археологийн малтлага судалгааны ажлын тайлан. УБ.,2017 он. Тайлан, хавсралт гэрэл зургийн хамт 59 хуудас.

2018 он

1. С.Чулуун, Э.Уртнасан, Ч.Энхтуул. Завхан аймгийн Тэс сумын нутаг дахь **“Сүм толгойн”** туурьт явуулсан археологийн малтлага судалгааны ажлын тайлан. УБ.,2018 он. Тайлан, хавсралт гэрэл зургийн хамт 34 хуудас.
2. С.Чулуун, Ч.Энхтуул. Дорноговь аймгийн Иххэт сумын нутаг дахь **“Хэсэг байшин”**-гийн туурьт явуулсан археологийн малтлага судалгааны ажлын тайлан. УБ.,2018 он. Тайлан, хавсралт гэрэл зургийн хамт 80 хуудас.
3. С.Чулуун, Ч.Энхтуул, Б.Батцоож, Н.Нандинцэцэг. Булган аймгийн Баяннуур сумын нутаг дахь **“Цогтын цагаан байшин”**-гийн туурьт явуулсан археологийн малтлага судалгааны ажлын тайлан. УБ.,2018 он. Тайлан, хавсралт гэрэл зургийн хамт 89 хуудас.
4. Ц.Цэрэндорж, Ч.Энхтуул. Булган аймгийн Рашаант сумын нутаг дахь Эрдэнэхамбын дээд хийд буюу **“Өвгөн хийд”**-ийн туурьт явуулсан археологийн малтлага судалгааны ажлын тайлан. УБ.,2018 он. Тайлан, хавсралт гэрэл зургийн хамт 77 хуудас.
5. С.Чулуун, Л.Эрдэнэболд, Э.Уртнасан. Булган аймгийн Дашинчилэн сумын нутаг дахь **“Хар бухын балгас”**-нд хийсэн археологийн малтлага судалгааны тайлан. УБ.,2018 он. Тайлан хавсралт зургийн хамт 70 хуудас.

2019 он

1. С.Чулуун, Э.Уртнасан, Ч.Энхтуул. Завхан аймгийн Тэс сумын нутаг дахь **“Сүм толгойн”** туурьт явуулсан археологийн малтлага судалгааны ажлын тайлан. УБ.,2019 он. Тайлан, хавсралт гэрэл зургийн хамт 203 хуудас.
2. С.Чулуун, Э.Уртнасан. Дорноговь аймгийн Иххэт сумын нутаг дахь **“Олон байшин”**-гийн туурьт явуулсан археологийн малтлага судалгааны ажлын тайлан. УБ.,2019 он. Тайлан, хавсралт гэрэл зургийн хамт 90 хуудас.
3. С.Чулуун, Ч.Энхтуул. Дундговь аймгийн Адаацаг сумын нутаг дахь **“Сүм хөх бүрд”** балгасанд хийсэн археологийн малтлага судалгааны тайлан. УБ.,2019 он. Тайлан, хавсралт гэрэл зургийн хамт 66 хуудас.

4. С.Чулуун, Г.Бямбарагчаа. **“XVII зууны монголын хот суурингууд”** аялал жуулчлалын менежментийн төлөвлөгөө. УБ.,2019 он. Тайлан хавсралт зургийн хамт 57 хуудас.
5. Г.Энхбат, Г.Анхсанаа. **“XVII зууны Монголын хотууд”** төсөлд хамрагдсан дурсгалт газрын хадгалалт, хамгаалалтын нөхцөл байдлын судалгаа ба хадгалалт хамгаалалтын зөвлөмж. УБ.,2019 он. Тайлан 39 хуудас.